



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 690

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл  
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 11 дүгээр зүйлийн 8, 9 дэх заалт, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 60 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 4.3, 4.10, 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Иргэн Г.Батбаярын бэлэглэсэн, нийт 10,000,000.00 (арван сая) төгрөгийн үнэ бүхий 1 дүгээр хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын үндсэн хөрөнгийн дансанд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Дорнод аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон 209,500,000.00 (хоёр зуун есөн сая таван зуун мянган) төгрөгийн үнэ бүхий 2 дугаар хавсралтад заасан хөрөнгийг Гадаадын иргэн, харьяатын газрын Зүүн бүс дэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

3.Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, Гадаадын иргэн, харьяатын газрын дарга Н.Ууганбаяр, Дорнод аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга М.Нямсүрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

3.1.Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3.Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг улсын бүртгэлээс шилжүүлэх;

3.4.Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ


Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 17 -ны өдрийн  
640 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ХОЙД БҮС ДЭХ ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Хэм жих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Автомашин зогсоол, Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум, 7-р баг, 1-р гудамж, Ган зам 2-р хэсэг гудамж, 5-р байр	ш	18 м2	10,000,000.00	10,000,000.00
	Нийт дүн		-		10,000,000.00 (арван сая)

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2020 оны 12 дугаар сарын 17 -ны өдрийн  
690 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ЗҮҮН БҮС ДЭХ ГАЗРЫН  
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр	Хэм жих нэгж	Тоо шир хэг	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Нийт үнэ (төгрөг)
1	Автомашин (Ландкрузер-200, ДОО 47-00)	ш	1	209,500,000.00	209,500,000.00
	Нийт дүн				209,500,000.00 (хоёр зуун есөн сая таван зуун мянган)